



**БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/25

Хөхбүрд

Г Хог хаягдлын менежментийг
сайжруулах тухай Г

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.5, Хөрс хамгаалах цөлжилтээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2, 8.4.3 заалт, Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор “2023-2025 оныг Монголд зочлох жил” болгон заралсантай холбогдуулан орчны бохирдлыг бууруулах, эрүүл аюулгүй, цэвэр орчныг бүрдүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах

Хавар, намрын улиралд төв суурин газар гэр хороолол, нийтийн эзэмшлийн байгууламж, гол усны сав газар, улсын болон орон нутгийн шинж чанартай авто зам дагуу, тусгай хамгаалалттай газар нутаг, ойн сан бүхий газар, уул уурхай, үйлдвэр, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн эзэмшил газар, газар тариалан талбай, хиймэл нуур, усжуулалтын хоолой, аймаг сумын нэгдсэн хог хаягдлын цэг, иргэн аж ахуй нэгжийн эзэмшил өмчлөлийн газарт бүх нийтийн цэвэрлэгээг сар бүр зохион байгуулах, иргэд олон нийтийг тухай бүр татан оролцуулах, хийсэн ажлын талаар сар бүрийн 20-нд тайлагнах, хог хаягдлыг бууруулах сургалт сурталчилгаа явуулах ажлыг зохион байгуулан ажиллахыг Иргэн, аж ахуй нэгж, байгууллагын дарга, захирал, багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Хог хаягдал бууруулах менежментийг хэрэгжүүлэх

Хог хаягдлыг цэвэрлэх, бууруулах менежментийг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 дугаар, хог хаягдал цэвэрлэх ажлын хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хог хаягдал ангилан ялгах сав байрлуулах

Иргэн, аж ахуй нэгж байгууллага нь ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж хэвших, байгууламж тус бүрийн гадна ангилан ялгах хог хаягдлын сав байрлуулах, дахин ашиглах бүтээгдэхүүн шил, хуванцар савыг тогтсон цэгт хаях, борлуулах, хог

• 642201153

хаягдлыг бүртгэх ажлыг эрчимжүүлэн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад даалгасугай.

4. Ариун цэврийн байгууламжийг сайжруулах

Албан байгууллага, аж ахуй нэгж, үйлдвэр үйлчилгээ эрхлэгчид, Аялал жуулчлалын бүс нутаг, гол усны сав газар, нийтийн эзэмшлийн талбайд байрлах шаардлага хангаагүй нүхэн жорлонг буулгах, хөрсийг ариутгах ажлыг 4 дүгээр сард зохион байгуулах, голын сав газрын эрүүл ахуйн бүсээс 200 метрээс гадна болон албан байгууллага, аж ахуй нэгж, нийтийн эдэлбэр газрын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж байгуулах ажлыг бүх нийтийн хэмжээнд зохион байгуулан ажиллахыг ажын хэсэгт хариуцуулсугай.

5. Хог хаягдлын хураамж төвлөрүүлэх

Хог хаягдлын хураамжийг сар бүрийн 25-ний дотор бүрэн төлж барагдуулах, татварыг хураах, ажлын хэсгийг 4 дүгээр, зарцуулах тайлагнах журмыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

6. Хог хаягдлыг цэвэрлэх, ангилан ялгах, шаардлага хангасан ариун цэврийн байгууламж байгуулах ажилд зарцуулагдах төсөв санхүүг тухай бүр шийдвэрлэх, төвлөрсөн орлогыг зориулалтыг дагуу зарцуулахад хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

